



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 4/20

Булган сум

Авто зам, гүүр хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 671 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар хийгдсэн, 11 нэрийн авто зам болон гүүр нийт 37,468,039,153 (гучин долоон тэрбум дөрвөн зуун жаран найман сая гучин есөн мянга нэг зуун тавин гурав) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)

Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Г.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот

байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын
хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Л.Лхамаа (Орон нутгийн өмчийн газрын удирдлага,

хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт холбогдох баримтыг баталгаажуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д даалгасугай.

3. Хүлээн авсан барилга байгууламжийг эзэмшигч байгууллагыг тогтоох нягтлан бодох бүртгэл, үндсэн хөрөнгийн тайланд тусгах асуудлыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6375010027